



**ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ
ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГЫН
ТУШААЛ**

2016 оны 04 сарын 13 өдөр

Дугаар 133

Улаанбаатар хот

Ажлын цаг ашиглалтад хяналт тавих,
журам батлах тухай

Монгол Улсын Яамны эрх зүйн байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6.1 дэх заалт, Зам, тээврийн яамны хөдөлмөрийн дотоод журмын 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Зам, тээврийн яамны нийт албан хаагчдын хөдөлмөрийн сахилга, хариуцлагыг бэхжүүлэх, ажлын цаг ашиглалтын үр дүнг нэмэгдүүлэх, цаг бүртгэлийн хурууны хээний хяналтын системийг хэрэгжүүлэх, түүнд тавигдах хяналтыг сайжруулах зорилгоор ажлын цаг ашиглалтад хяналт тавих журмыг хавсралтаар баталсугай.

2. Энэ тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн захиргааны удирдлага, хууль эрх зүйн газар /Н.Ганибал/-т даалгасугай.

ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА

Ж.БАТ-ЭРДЭНЭ



Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2016 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн 13 дугаар тушаалын хавсралт

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМНЫ АЛБАН ХААГЧДЫН, АЖЛЫН ЦАГ АШИГЛАЛТАД
ХЯНАЛТ ТАВИХ ЖУРАМ

УХА0115 5919487

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэхүү журмын зорилго нь Яамны эрх зүйн байдлын тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль болон Зам, тээврийн яамны “Хөдөлмөрийн дотоод журам”-д нийцүүлэн нийт албан хаагчдын хөдөлмөрийн сахилга, хариуцлагыг бэхжүүлэх, цагийн бүртгэл, ажлын цаг ашиглалтыг сайжруулах, цаг бүртгэлийн хурууны хээний хяналтын систем тэдгээрт тавих хяналт шалгалтыг хэрэгжүүлэхэд холбогдсон харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Энэхүү журмыг Зам, тээврийн яамны нийт албан хаагчид дагаж мөрдөнө.

Хоёр. Цахим бүртгэлийн системд бүртгүүлэх

- 2.1. Нийт албан хаагчид “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8 дугаар зүйлийн 8.2-т зааснаар ажилд ирэх, ажлаас тарах цагаа цахим бүртгэлд хурууны хээг уншуулж бүртгүүлнэ.
- 2.2. Дараах тохиолдолд албан хаагчийг ажил тасалсанд тооцно Үүнд:
 - 2.2.1. Албан хаагч нь “Хөдөлмөрийн дотоод журам”-ын 8 дугаар зүйлийн 8.3-т зааснаар “Гадуур ажилласан тухай бүртгэлийн дэвтэр”-т тэмдэглэл хийгээгүй бол;
 - 2.2.2. Албан хаагч нь томилолтоор ажилласан, өвчтэй, чөлөөтэй, ээлжийн амралттай зэрэг хүндэтгэн үзэх шалтгаантайгаас бусад тохиолдолд цахим бүртгэлд бүртгүүлээгүй бол;
 - 2.2.3. Хүндэтгэн үзэх шалтгааны улмаас ажилдаа ирээгүй тохиолдолд харъяалах газар, хэлтсийн /нэгж / даргад утсаар албан ёсоор мэдэгдэн мөн цахим бүртгэл хариуцсан албан хаагчид мэдэгдэн тусгай тэмдэглэгээ хийлгэсэн байна. Харъяалах газар, хэлтсийн /нэгж/ дарга мөн цахим бүртгэл хариуцсан албан хаагчид мэдэгдэн бүртгэл, тэмдэглэгээ хийгдээгүй бол;
 - 2.2.4. Хүндэтгэн үзэх шалтгаангүйн улмаас цахим бүртгэлд хурууны хээг дутуу оруулсан бол.

Гурав. Цаг ашиглалтын байдал, түүнд хяналт тавих

- 3.1. Цахим бүртгэлийн төхөөрөмж, гадуур ажилласан тухай бүртгэлийн дэвтэрт Төрийн захиргааны удирдлага, хууль эрх зүйн газар гэнэтийн болон гүйцэтгэлийн хэлбэрээр хяналт тавина.
- 3.2. Цахим бүртгэлийг сард 2 удаа буюу сарын эхний, сүүлийн цалин тооцох өдрийн өмнөх өдөр цахим бүртгэл хариуцсан албан хаагч, нягтлан бодогчид ажлын цагийн тооцоог гаргаж өгнө. Нягтлан бодогч цалинг тооцохдоо цахим бүртгэл хариуцсан албан хаагчийн гаргаж өгсөн тайланг баримтална.

3.3. Төрийн албан хаагчийн үр дүнгийн гэрээ, хөдөлмөрийн гэрээний биелэлтийг дүгнэхдээ ажлын цаг ашиглалтын байдлыг харгалзан үзнэ.

3.4. Цахим бүртгэлийн системийн хэвийн ажиллагааг цахим бүртгэл хариуцсан ажилтан бүрэн хариуцна.

Дөрөв. Хариуцлага

4.1. Тус яамны албан хаагч нь энэхүү журмыг 3 ба түүнээс дээш удаа зөрчсөн тохиолдолд "Хөдөлмөрийн дотоод журам"-ын 14 дүгээр зүйлд заасан сахилгын шийтгэл ногдуулах үндэслэл болно.

4.2. Хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хожимдсон, тасалсан тохиолдолд цагийн бүртгэлийг үндэслэн сар бүрийн ажлын цагийн балансас хоцорсон хугацааны нийлбэрийг цалингаас хасна. ***/Цагийн үнэлгээг 1 өдрийн ажлын хөлсөнд хуваан тооцоолох ба тухай сард ажлаас хоцорсон минутын нийлбэр 31 минутаас дээш бол 1 цаг тасалсанд тооцно. Жиш: Та 2 цаг 31 минут хоцорсон бол 3 цагаар тооцно/***

Тав. Бусад зүйл

5.1. Энэ журмын хэрэгжилтэд холбогдох мэргэжилтэн, нягтлан бодогч нар тогтмол хяналт тавьж удирдлагыг мэдээллээр хангаж ажиллана.

5.2. Энэхүү журмыг 2016 оны 04 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө

ЗАМ, ТЭЭВРИЙН ЯАМ